



БАЯНХОНГОР АЙМАГ
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 13 өдөр

Дугаар

1/12

Хөхбүрд

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, цахим төлбөрийн баримт олголтод хяналт тавих сайжруулах ажлыг хэрэгжүүлэх ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалт, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 12/54 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөө”-ний 2 дугаар зүйлийн 2.1.1 дэх зорилт, арга хэмжээ, аймгийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн “Төлбөрийн баримт олголтыг эрчимжүүлэх” тухай А/208 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, цахим төлбөрийн баримт олголтод хяналт тавих ажлыг сайжруулах ажлыг хэрэгжүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

М.Жавзансүрэн Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүд:

Д.Эрдэнэбулган Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн

Р.Содном Хэсгийн цагдаа

С.Өлзий-Орших Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:

Б.Үлэмжсонин Татварын Улсын байцаагч

2.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг хэрэгжүүлэх, цахим төлбөрийн баримт олголтод хяналт тавих ажлыг эрчимжүүлэх ажлын хэсэг нь Нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын нэгдсэн системд татвар төлөгчдийг бүрэн холбох, төлбөрийн баримт олголтын хувийг 90-ээс дээш хувьд

042501361

хүргэж ажиллах үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөөг батлуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлах (М.Жавзансүрэн)-д үүрэг болгосугай.

3.Бараа, ажил үйлчилгээ худалдахдаа, худалдан авахдаа цахим төлбөрийн баримт олгохгүй байгаа бизнес эрхлэгч хувь хүн, хуулийн этгээдэд зөвлөгөө, мэдээлэл өгөх, мэдэгдэл, шаардлага хүргүүлэх ажлыг эрчимжүүлж, иргэдээс ирүүлсэн гомдол, мэдээллийн дагуу тухай бүр хариуцлага тооцож ажиллахыг Татварын Улсын байцаагч Б.Үлэмжсонинд даалгасугай.

4.Ажлын хэсэг нь хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, мэдээг улирал бүр дүгнэж, Засаг даргын зөвлөлийн бүрэлдэхүүнд өмнөх улирлын гүйцэтгэлийг дараа сарын 05-ны дотор тайлагнаж байхыг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга (Б.Үлэмжсонин)-д үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Д.Гансүх)-д даалгасугай.

ДАРГА  Б.БЯМБАДОРЖ



